



ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ
ХАНГАЛТГҮЙГЭЭС БОЛЖ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ЧАНАРГҮЙ БОЛОХ СӨРӨГ ҮР
ДАГАВАР ГАРЧ БАЙНА.

УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: **ӨВА-2024/18-14-ШТА-ГА**

Өвөрхангай аймаг



Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газрын
Дарга, Тэргүүлэх аудитор **О.Батжаргал**

Утас:70323253, Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: **Д.Гансүх**

Утас:70323833, Цахим хаяг: gansukhd@audit.gov.mn

Ахлах аудитор: **С.Шийлэгмаа**

Утас:70323833, Цахим хаяг: shiilegmaas@audit.gov.mn

Аудитор: **Б.Баяртогтох**

Утас:70323108, Цахим
хаяг: bayartogtokhb@audit.gov.mn

Аудитор: **П.Норпил**

Утас: 70323833, Цахим хаяг: norpilp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг

Дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Open.audit.mn



АГУУЛГА

4

Хүснэгтийн товъёг.....

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

5

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....

6

Аудитын дүн: Аудитаар нийт 27,828.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 27,828.1 сая..... төгрөгийн 5 албан шаардлага, 3 зөвлөмж өгч, 27 тэрбум 739.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцов.....

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь холбогдох тооцоолол, баримт бичигт үндэслэгдэж боловсруулсан байна.....

А.1. Зарим барилга байгууламжийн зургийн даалгаварт тусгайлан заасан норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй байна.

А.2. Төсвийн тухай хуульд төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаатай уялдуулаагүй, тухайн онд санхүүжих дүнг ажил эхлэх төдий баталсан байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Бүлэг 2. Зарим барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хийгээгүй, ажлын гүйцэтгэл чанаргүй, захиалагч, зохиогчийн үе шатны хяналт хангалтгүй байна.....

Б.1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа зарим барилга угсралтын ажлыг зураг төсвийн дагуу хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлийн чанар хангалтгүй байна.

Б.2. Бүх шатны хяналтыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Б.3. Хэрэгжүүлж дүүссэн барилга байгууламжийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна. .

Бүлэг 3. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.....

В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна..

В.2. Өвөрхангай аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.....

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд: 26

ЗӨВЛӨМЖ: 26



Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБ	Барилга, хот байгуулалт
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БУ	Барилга угсралт
БШУ	Боловсрол шинжлэх ухаан
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТӨӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс

**Хүснэгтийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Ажил эхлүүлэх төдий санхүүжилт тусгаагдсан төсөл, арга хэмжээнүүд /Сая төгрөг/	8

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Хужирт сумын цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл	10
Зураг 2	Уянга сумын сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл	11
Зураг 3	Жаргалант багийн сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл	12
Зураг 4	Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэл	13
Зураг 5	Зооноз өвчин судлаын барилгын ажлын гүйцэтгэл	14
Зураг 6	Хайрхандулаан сумын цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл	15
Зураг 7	Хужирт сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэл	15
Зураг 8	Улаан дэвтрийн хөтлөлт	16
Зураг 9	Чанаргүй хийгдсэн ажлын гүйцэтгэл	18

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1		

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Магадлалын дүгнэлт болон барилга угсралтын гэрээнүүдийн хугацааг харьцуулсан хүснэгт	8
Хавсралт 2		



Аудитын нэр	Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Аудитын код	ӨВА-2024/18-14-ШТА-ГА
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын дэд төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.</p>
Аудитын зорилт	<p>Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн улсын, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.</p> <p>Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх, ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх, ➤ Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,
Аудитын хамарсан хүрээ	Аудитаар Өвөрхангай аймагт 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХБТХОХ, ГХБХБГ, ОНӨГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайланг хамруулан төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг хийлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхдээ аудитын стандарт АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго зорилт асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах зэрэг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, ахлах аудитор С.Шийлэгмаа, аудитор Б.Баяртогтох, П.Норпил нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.02.25-2024.04.19-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

**Аудитын
тайлангийн бүтэц**

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт зөвлөмж, холбогдох байгууллагын санал хэсгээс бүрдсэн.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС БОЛЖ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ ЧАНАРГҮЙ БОЛОХ СӨРӨГ ҮР ДАГАВАР ГАРЧ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт 13,484.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 13,484.6 сая төгрөгийн 4 албан шаардлага, хариуцлага тооцох 1 албан шаардлага, 4 зөвлөмж өгч, 13 тэрбум 395.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцов.

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь холбогдох тооцоолол, баримт бичигт үндэслэгдэж боловсруулсан байна

А.1. Зарим барилга байгууламжийн зургийн даалгаварт тусгайлан заасан норм, дүрмийн дагуу төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй байна.

Өвөрхангай аймагт 2023 онд БШУС, Соёлын сайд, БХБС, ЗГХЭГ-ын багцаас 2020-2023 онд хэрэгжиж дуусах 26 төсөл арга хэмжээний архитектур төлөвлөлтийн даалгавар, зургийн даалгаварт ерөнхий төлөвлөгөө, барилга бүтээц, халаалт агаар сэлгэлт, цэвэр бохир усны шугам, гадна цэвэр бохир ус, цахилгаан хангамж, холбоо дохиолол зэрэг нь батлагдсан зургаас зөрүүгүй бүрэн тусгагдсан байна.

Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээний ажлын төвөгшил нь бүгд дунд төвөгшилтэй барилга байгууламжийн ангилалд хамаарч байна

Эрүүл мэндийн сайдын багцаас барилга байгууламжийн зураг, төслийг боловсруулахад эрх бүхий байгууллагаас олгосон зургийн даалгаварт тусгайлан Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 03 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" /БНБД 31-22-21¹/ барилгын норм, дүрмийн шаардлагыг хангаж гүйцэтгэхээр тусгаагүй тул дээрх норм дүрмийг бүх төрлийн эмнэлэгийн барилгын зураг төсөл боловсруулахад мөрдлөг болгоогүй байна. Тухайлбал:

- **Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/:** "Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 5095:2017 стандартын дагуу зураг, төсөл хийж, улмаас эмнэлгийн зориулалттай хүчилтөрөгчийн хоолойн систем, төрөх тасгийг байгуулалт төлөвлөгдөөгүй.
- **Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/:** "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" /БНБД 31-22-21/ барилгын норм, дүрмийн шаардлагыг хангаагүй тул төрөх тасгийн зохион байгуулалт төлөвлөгдөөгүй.

¹ Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх

Зарим барилгын ажлын зураг төслийг бүрэн боловсруулаагүй, тусгаагүй орхигдуулсан, дутуу тооцсон, барилга, байгууламжийн зураг, төсвийг захиалагч болон хэрэглэгчийн шаардлагад нийцүүлээгүй байна. Үүнд:

- **Соёлын төвийн барилга /Өвөрхангай, Баянгол сум/:** Зураг төсөлд гадна шугам сүлжээ, хуучин барилга буулгалтын төсвийг тусгаагүй.
- **Музейн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/:** Музейн гол үйл ажиллагаа явуулах үзүүлэг, дэглэлт, дотор интерьер дизайны ажлын тоо хэмжээ зураг төсөвт тусгаадаагүй. Соёлын яам, орон нутгийн удирдлага, аймгийн музей гэх зэрэг газрууд хамтран музейн барилгын үзүүлэг дэглэлт, үзвэрийн танхимийн дотор заслын ажлын зургыг “Скайн лайн” ХХК-аар гүйцэтгүүлж байгаа.
- **Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Хужирт сум/:** Барилгын зураг төсөлд тусгаадаагүй боловч зайлшгүй хийгдэх шаардлагатай дутуу орхигдуулсан гадна 10кв-н ЦДАШ-ийн трассын өөрчлөлт нэмэлтээр хийгдэх шугам сүлжээний ажлын тоо хэмжээ гаргаж магадлал хийгдсэн.
- **Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/:** Тус барилгын зураг төсөл зохиогч "Жаргалант хийц" ХХК нь зураг, төсөлд гадна гэрэлтүүлэг тусгаадаагүй.
- **Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/:** эмнэлгийн зориулалттай хүчилтөрөгчийн хоолой, систем төлөвлөөгүй.
- **Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/:** Гадна тохижилтын ажлыг зурагт тусгаагүй.

Төсөл, арга хэмжээний зураг төсөл, ажлын даалгавар, техникийн баримт бичгийг Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын хавсралт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-д заасан зохицуулалтын дагуу хийж боловсруулж байна.

Барилга байгууламжийн угсралтын ажилд архитектур төлөвлөлтийн даалгаврыг боловсруулахдаа хот, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, барилгын зориулалт, хүчин чадал, үндсэн хийцлэл, хэмжээ, өндөр, давхрын тоо, инженерийн хангамжийн сүлжээнд холбогдох, техникийн нөхцөл зэрэг ерөнхий төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн боловсруулж байна. Барилга байгууламжийн зам, талбай, ногоон байгууламж, цахилгааны эх үүсвэр, гадна шугам сүлжээний холболтын төлөвлөлтийг мөн адил тусгаж байна.

Эрүүл мэнд, соёлын сайдын багцаас барилгын ажлын зурагт тусгагдсан боловч, төсөвт заагдсан ажлын тоо хэмжээний зөрүүтэй 3 төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал,

- **Соёлын төвийн барилга, 400 суудал /Өвөрхангай, Хужирт сум/:** 1026/2021 дугаартай магадлалын төсөвт ажлын тоо хэмжээ, зураг төслөөсөө зөрүүтэй магадлал хийсэн.
- **Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/:** Гадна металл пасад, чулуун хавтан, хашаа зэргийг дутуу тооцсон.
- **Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/:** Гадна тохижилтын зурагт газрын хэвгийг тооцоолоогүй, талбайг тэгшлэхэд их хэмжээний газар шорооны ажлын зөрүү үүсэхээр тооцоолол үүссэн,

Эдгээр төсөл, арга хэмжээний зураг, төсөв нь зөрүүтэй байгаа нь барилгын удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болж байна.



А.2. Төсвийн тухай хуульд төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаатай уялдуулаагүй, тухайн онд санхүүжих дүнг ажил эхлэх төдий баталсан байна.

Улсын төсвийн 2019-2022 оны хөрөнгө оруулалтаар аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээнээс 2023 онд дамжин хэрэгжиж байгаа 93,789.7 сая төгрөгийн 37 төсөл, арга хэмжээний 90.0 хувь нь төлөвлөлтийн шаардлага хангагдаагүй байхад баталсан нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.2. “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар

баталгаажсан төсөвтэй байх”, 29¹.2.3 “техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх”, 29¹.2.4 “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх”-т заасныг тус тус зөрчсөн байна. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангахгүй, ажлууд нь иж бүрэн чанартай хийгдэхгүй, ажил гүйцэтгэх явцад өөрчлөлт орох шаардлага үүсэж, төсөв өртөг нэмэгдэх хүндрэл учруулсаар байна.

Төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлт болон барилга угсралтын гэрээнүүдийн хугацааг харьцуулсан байдлаар хүснэгтээр үзүүлснийг Хавсралт 1-ээс харарх.

МУ-ын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдсан 14 төсөл арга хэмжээ нь анх 2021 оны төсвийн тухай хуульд батлахдаа хэрэгжихээр төлөвлөсөн хугацаатай уялдуулахгүйгээр санхүүжилтийг ажил эхлүүлэх төдий тусгагдсан байна. Тодруулбал:

Ажил эхлүүлэх төдий санхүүжилт тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд /Сая төгрөг/ Хүснэгт 1

2021 оны төсвийн хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
X.4.1.5	Цагдаагийн тасгийн барилга /Өвөрхангай, Хужирт сум/	2021	2022	380.0	100.0
X.4.1.6	Цагдаагийн тасгийн барилга /Өвөрхангай, Богд сум/	2021	2022	300.0	100.0
XIII.1.1.265	Бага сургуулийн барилга, 240 ор /Өвөрхангай, Өлзийт сум/	2021	2022	1,500.0	200.0
XIII.1.1.266	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум, 2 дугаар сургууль/	2021	2022	1,000.0	200.0
XIII.1.1.247	Сургуулийн барилгын өргөтгөл, 120 суудал /Өвөрхангай, Уянга сум, Жаргалант баг/	2021	2022	1,000.0	200.0
XIII.1.1.246	Сургуулийн номын сан, урлаг заалны өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум, 4 дүгээр сургууль/	2021	2022	1,200.0	200.0
XIII.1.1.248	Сургуулийн барилга, 440 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	2021	2022	5,000.0	200.0
XIII.1.1.251	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум/1	2021	2022	1,300.0	200.0
XIII.1.1.250	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум/	2021	2022	1,300.0	200.0
XIII.1.1.249	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, урлаг заал /Өвөрхангай, Хужирт сум/	2021	2022	250.0	100.0
XIX.1.50	Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2021	2022	1,800.0	200.0
XIX.1.51	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/	2021	2022	1,000.0	200.0
XIX.1.52	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/	2021	2022	1,000.0	200.0
XXII.1.7	Прокурорын газрын барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2021	2022	1,600.0	200.0

Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 1 төсөл, арга хэмжээг 2023 оны төсвийн тухай тусгахгүй, санхүүжилт төлөвлөхгүйгээр дараах ТАХ-г орхигдуулсан байна.



- **Соёлын төвийн барилга /Баруунбаян-Улаан сум/:** төсөл, арга хэмжээний ТЭЗҮ хийгдээгүй, зураг төсвөө батлуулаагүй, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдоогүй байхад худалдан авах ажиллагааг зарлаж Ти эл жи групп ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн БУ-19/2022-СОЯ/202212005 дугаартай гэрээг байгуулжээ. МУ-ын 2022 оны төсвийн тухай хуульд 500.0 сая төгрөг тусгагдсан нь барилгыг ажил эхлүүлэх төдий тусгаж, 2023 оны төсвийн тухай хуульд орхигдсон байна. Барилга угсралтын явц нь суурийн ажил, нэг давхрын арга бүтээц хийгдээд зогссон гүйцэтгэл 25.0 хувьтай байна.

А.3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг 2023 оны 278 дугаар тогтоолоор хүчингүй болгож, шинэчлэн баталсан байна.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймагт 2019-2022 оноос хойш хэрэгжиж байгаа нийт 93,789.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 37 төсөл, арга хэмжээний 37784.3 сая төгрөгийн санхүүжилтийг тайланд онд олгожээ.

Аудитаар ГХБХБГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 37 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэхийг тулган баталгаажуулалт хийхэд 1,985.5 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй нэг төсөл, арга хэмжээний 691.3 сая төгрөгийн буюу 35.0 хувийн санхүүжилт илүү олгосон байна. Тухайлбал:

Сургуулийн барилгын урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилга /Өвөрхангай, Уянга сум/ Тус төсөл арга хэмжээг СТНАА ХХК гүйцэтгэхээр 2022 онд гэрээ байгуулсан боловч 2024.04.02-ны өдрийн байдлаар барилгын явц 40.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Бүлэг 2. Зарим барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хийгээгүй, ажлын гүйцэтгэл чанаргүй, захиалагч, зохиогчийн үе шатны хяналт хангалтгүй байна.

Б.1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа зарим барилга угсралтын ажлыг зураг төсвийн дагуу хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлийн чанар хангалтгүй байна.

Аймгийн ГХБХБГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн 93,789.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 37 барилга, байгууламж барих төсөл, арга хэмжээг хамруулан барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу хугацаанд нь гүйцэтгэсэн эсэхийг газар дээр нь очиж тодруулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

➤ Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, урлаг заал /Өвөрхангай, Хужирт сум/ Сонор гуа солюшн ХХК нь гүйцэтгэж, барилгыг ашиглалтад оруулах улсын комисс 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн ББКД-62-16/23 дугаартай актаар хүлээн авсан, 441.7 сая төгрөгийн өртөгтэй баригдсан тус барилгын чанар байдал хангалтгүй. Тодруулбал:

- Ханын хагарал, цууралт ихтэй, цонхны тавцангаар сийгэлт их, коридорын хана заслын ажил нь арзгар хүүхэд унавал нүүр, гар, хөл урах эрсдэлтэй, дотор агааржуулалты системийн ажиллагаа муу байна.
- Дээврийн парпедийн өрлөг хэсгийн чулуутай хар цаасыг дутуу наагдсан, ам дарж тогтоосон төмөр, хар цаас хоёрын хооронд шавардлага хийсэн байгаа нь борооны ус нэвчих эрсдэлтэй, гадна хаяавч чанаргүй хийгдсэн, барилга хүлээн авах комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

Хужирт сумын цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл Зураг 1



➤ С

ургуулийн барилгын урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилга /Өвөрхангай, Уян

га сум/ -ыг сургуулийн өргөтгөлийн барилгыг гүйцэтгэгч СТНАА ХХК гүйцэтгэж буй барилгын ажлыг гүйцэтгэхдээ угсралтын цутгамал бетон, төмөр бетон бүтээцийн норм дүрэм баримтлаагүй, төмөр бетон багана, дам нуруу, хучилтын ажлын арматурыг боохдоо холбогдох норм дүрмийг баримтлаагүйн улмаас цутгалтын явцад арматур ил гарсан. Дам нурууны ажлын гүйцэтгэлээс шалтгаалан цууралт, суулт өгөх эрсдэлтэй болсон байна. Магадлал хийгдсэн зургаар гадна хана нь 250 мм хөнгөн блок дүүргэгч ханыг 100 мм зузаан, 25кг/м² нягттай EPS хөөсөнцөр хавтангаар дулаалж, 120мм өнгөлгөөний тоосгон өрлөгөөр өнгөлөх гэснийг металл хавтангаар хийхээр материалыг татсан нь захиалагч, зохиогч, гүйцэтгэгч аман хэлцлээр зураг өөрчилсөн;

Уянга сумын сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл Зураг 2

➤ Сургуулийн барилгын өргөтгөл, 120 суудал /Өвөрхангай, Уянга сум, Жаргалант баг/-тай барилгын ажлыг Дүүрэн цацрах ХХК гүйцэтгэхээр барилга угсралтын гэрээг 2023 онд 2,470.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр байгуулжээ. 2024.04.02-ны өдрийн байдлаар барилгын явц 30.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Бетоны цутгалтын ажлыг гүйцэтгэхдээ угсралтын цутгамал бетон, төмөр бетон бүтээцийн норм дүрэм баримтлаагүй, төмөр бетон багана, дам нуруу,

хучилтын ажлын арматурыг боохдоо холбогдох норм дүрмийг баримтлаагүйн улмаас цутгалтын явцад багана цүлхийсэн, нэг давхрын хар шал



зут
гах
даа
хөр
сий
г
няг
тру
ула
агү
й,
зах
иал
агч

ийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;



Жаргалант багийн сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэл Зураг 3

Магадлал хийгдсэн зургаар гадна хана нь 360 мм хөнгөн блок дүүргэгч ханыг 100 мм зузаан, 25кг/м² нягттай EPS хөөсөнцөр хавтангаар дулаалж, 120 мм өнгөлгөөний тоосгон өрлөгөөр өнгөлнө гэснийг металл хавтангаар хийхээр материалыг татсан нь захиалагч, зохиогч, гүйцэтгэгч аман хэлцлээр зураг өөрчилсөн;

➤ Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 15 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум, 5 дугаар баг/-той барилгын ажлыг БАКО Констракшн ХХК гүйцэтгэж, байнгийн ашиглалтад хүлээн авсан. Барилгыг ашиглалтад хүлээн авах комиссын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, таазны материалын чанар, бэхэлгээ муу, ханын хагарал, цууралттай, төрөх тасгийн агааржуулалтын төхөөрөмж ажилдаггүй, агааржуулалт муу;

➤ Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хужирт сум/-ийн ажлыг Воком констракшн ХХК гүйцэтгэж буй барилгыг гүйцэтгэхдээ өрлөгийн ажлыг норм, стандартын дагуу гүйцэтгээгүй, хүзүүвч хэсгийн дээврийн ус уналт хангалтгүй, зураг, төсөв тусгагдаагүй эмнэлгийн гал тогоог нэг давхарт хийлгүүлэх, хоёр давхарын төрөх өрөөний байрлалыг өөрчлөх

захиалагч, зохиогч, гүйцэтгэгч аман хэлцлээр зураг өөрчлөлт оруулахаар хамар хананы ажлыг хийлгүй орхигдуулснаас болж барилгын ажил удааширсан;



Хужирт сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлын гүйцэтгэл Зураг 7

➤ Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/-той барилгын ажлыг Би энд Би Констракшн ХХК гүйцэтгэж, гүйцэтгэл 55 хувьтай байна. Зураг, төсөвт гадна дүүргэгч ханыг 0.30 м /мак/-ын блокоор хийхээр төсөвлөснийг 200 мм-ээр өрсөн нь захиалагч, зохиогч, гүйцэтгэгч нар нь аман хэлцлээр зураг өөрчилсөн, өрлөгийн ажлыг норм, стандартын дагуу гүйцэтгээгүй, тоосгыг ташуу өрсөн;

Хархорин сумын нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэл Зураг 4






➤ Зооноз өвчин судлалын төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/-ын ажлыг Оазислэнд ХХК гүйцэтгэж 2023 оны 1 сард ашиглалтад оруулсан. Ашиглалтын явцад хана хагарал, цууралттай, паркетан шалны шахалт муугаас завсар гарч ангайсан, шилэн пасадны дулаан алдалт ихтэй, халаалтын радиотар паарны чанар муугийн улмаас задарч ус алдсан, дээврээс ус гоожсон, хаяавч хагарч суусан, усанд урссан, ХБИ-д зориулсан налуу шатны чулуун тавцангууд ховхорч унасан, В1 давхар руу шугам даган үерийн ус орсны улмаас хаалга, шалны будаг дэвтэж ховхорсон;

Зооноз өвчин судлалын барилгын ажлын гүйцэтгэл Зураг 5



➤ Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Хайрхандулаан сум, 6 дугаар баг/-той барилгын ажлыг Оазислэнд ХХК гүйцэтгэж барилга ашиглалтад оруулах комисс хүлээн авсан. Ашиглах явцад гадна бохирын шугам хөлдөлттэй, худагт шат хийгээгүй, дээврээс ус гоожсон, хана, таазны хагаралт үүссэн.

Хайрхандулаан сумын цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл Зураг 6



Дүгнэлт: Дээрх зөрчилтэй 25,567.9 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 8 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг, төсвийн дагуу гүйцэтгэх хугацаатай албан шаардлага хүргүүлж байна.

Б.2. Бүх шатны хяналтыг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн ТЕЗ нь 2022 оноос дамжин ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс хүлээн авч ашиглалтад оруулсан 29 барилга байгууламж байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь барилга байгууламжийн угсралтын ажилд техникийн хяналт гүйцэтгэх гэрээг ГХБХБГ-тай, зохиогчийн хяналтыг зураг, төсөл зохиогчтой гэрээ байгуулж, хяналт хэрэгжүүлэх ажлын үе шатны хуваарийг баталсан байна.

Захиалагчийн хяналт буюу техникийн хяналтыг нэг барилга байгууламж дээр дундажаар 14 удаагаас доошгүй очиж хяналт хийхээр хуваарийг баталсан.

Аудитаар ашиглалтад орсон, үргэлжлэн явагдаж байгаа барилга, байгууламжуудыг газар дээр нь очиж улаан дэвтрийн хөтлөлт бүртгэлийг шалгаж үзэхэд:

- ✚ захиалагчийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх явцдаа өмнөх хяналтаар илрүүлсэн алдаа зөрчлийн биелэлтийг гүйцэтгэх хугацаа өгдөггүй, биелсэн эсэхийг дүгнэдэггүй,
- ✚ Үе шатны ажилд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгч байгууллагаар хийлгэсний дараа, дараагын үе шатны ажлыг эхлүүлдэггүй;
- ✚ Барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй;

Улаан дэвтрийн хөтлөлт Зураг 8

Дээрх асуудалд ГХБХБГ-аас тодруулга авахад “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч нь санхүүгийн алдагдалд орсон тул гүйцэтгэгч болон захиалагчийн нөхцөл байдлыг дордуулахгүйн тулд санхүүжилтийг авч өгөх зорилготой актийг үйлдсэн гэх тайлбар өгсөн.

Захиалагч Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь барилга байгууламжийн угсралтын ажилд техникийн хяналт гүйцэтгүүлэх гэрээг ГХБХБГ-тай байгуулсан. Гэтэл техникийн хяналт гүйцэтгэх ГХБХБГ нь гэрээний гуравт тусгагдсан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Барилга байгууламжийн зураг төсөл, зохиогчийн хяналт хийх гэрээ хийж, хяналт тавин ажиллан байгаа ч төсөл арга хэмжээний ажлуудад зохиогчийн хяналт хийх гэрээний хавсралтад тусгагдсан хяналт хийх хуваарийн дагуу ажиллаагүй, ажлын талбар дээр 1-2 удаа хяналт хийсэн ажлын тайлан болон нэгдсэн дүгнэлтийг үндэслэн зураг төсөв, зохиогчийн хяналтын зардлыг олгосон байна.

Гэрээний хавсралтаар баталгаажсан зохиогчийн хийх хяналтын үе шатны хуваарийн дагуу 7-оос дээш удаа, хийгдэх давтамжийн тоог ажлын онцлогт тохирсон байдлаар гэрээнд зааж өгчээ. Зохиогчийн зүгээс хийгдсэн хяналтын тоо, давтамж цөөн байгаа нь ажлын гүйцэтгэлд шууд сөргөөр нөлөөлж байна. Карказ цутгалт, ханын дүүргэлт, хамар ханын өрлөг, дээврийн ажил зэрэгт хийгдэх зохиогчийн хяналтыг тухай бүрд хэрэгжүүлээгүйн улмаас дээврээс ус гоожих, суурь, хананд цууралт өгөх, багана, дам нурууны цутгалт чанаргүй хийгдэх зэрэг эрсдэлүүд бий болж байна.

Чанаргүй хийгдсэн ажлын гүйцэтгэл Зураг 9



Цаашид зохиогчийн хяналт хийх хуваарийн дагуу бодитоор хяналт хийсэн эсэхийг дүгнэн зохиогчийн хяналтын зардлыг олгож байх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2023 онд 19 барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс ажиллаж бүх гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтийг гаргуулж авалгүйгээр ашиглалтад оруулсан зөрчлүүд гарч байна. Тодруулбал:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Арвайхээр сум/-той цэцэрлэгийн барилгыг Ганнэгдэл ХХК гүйцэтгэж, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврын биелэлт 40.0 хувьтай байхад;
- Сургуулийн номын сан, урлаг заалны өргөтгөл /Өвөрхангай, Арвайхээр сум, 4 дүгээр сургууль/-ийн ажлыг Гурван тахилгат оргил ХХК гүйцэтгэж, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврын биелэлт 00.0 хувьтай байхад;
- Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Өвөрхангай, Арвайхээр сум/-тай сургуулийн барилгыг Юу зет эрдэнэ ХХК гүйцэтгэж, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврын биелэлт 50.0 хувьтай байхад;
- Сургуулийн барилга, 320 суудал, спорт заал /Өвөрхангай, Хужирт сум/-ны сургуулийн барилгыг Тэд констракшн ХХК гүйцэтгэж, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврын биелэлт 31.2 хувьтай байхад тус тус ашиглалтад хүлээн авсан байна.

Дараах барилга байгууламжууд нь комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжүүлээгүй байхад ашиглалтад оруулсан. Тухайлбал:

- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум/-той цэцэрлэгийн барилгыг Шилүүстэй хайрхан ХХК гүйцэтгэсэн, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, урлаг заал /Өвөрхангай, Хужирт сум/-ны барилгын ажлыг Сонор гуа солюшн ХХК гүйцэтгэсэн, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Хайрхандулаан сум, 6 дугаар баг/-той цэцэрлэгийн барилгын ажлыг Оазислэнд констракшн ХХК гүйцэтгэсэн, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,
- Сургуулийн барилга, 440 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/-тай сургуулийн барилгын ажлыг Бако констракшн ХХК гүйцэтгэсэн, комиссын гишүүдын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй,

Иймд хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Б.3. Хэрэгжүүлж дууссан барилга байгууламжийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын даргын 2023.12.28-ний өдрийн а/62 тоот захирамжаар 2023 онд ашиглалтад орсон улс, орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоон бүртгэлд тусгасны дотор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 47,204.6 сая төгрөгийн 26 барилга байгууламж, 56,408.8 сая төгрөгийн 21 дуусаагүй барилга байгууламжийг хөрөнгөд бүртгэсэн байна.



Аудитаар хөрөнгийн бүртгэлийг тулган шалгахад дараах зөрчлүүд илэрч байна. Тухайлбал Арвайхээр сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилга, Баянгол сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын гүйцэтгэл 90.0-95.0 хувьтай гээд барилга ашиглалтад оруулах комисс ажиллаж хүлээн аваагүй байхад 2021 оноос хойш дээрх 2 барилгыг ашиглагч байгууллага нь ашиглаад 3 жилийн нүүр үзэж байна.

Аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн тайланд 6,849.6 сая төгрөгөөр дуусаагүй барилгын бүртгэлтэй байна.

Барилга ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад ашиглалтад оруулж үйл ажиллагааг явуулж байгаа нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6. “дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно”, 48 дугаар зүйлийн 48.3. “гэрчилгээ олгогдоогүй, дуусаагүй барилга байгууламжид үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн;

Хархорин сумын Эрдэнэзуу музейн “Аялал жуулчлалын гудамж” төслийн гүйцэтгэгч ДШЛ ХХК, Өв дулаан ХХК ажлыг хүлээн авах улсын комисс ажиллаагүй байхад аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн тайлангийн дуусаагүй барилга байгууламжид бүртгэлтэй байсан 1,410.6 сая төгрөгийн хөрөнгийн Хархорин сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгүүлэх аймгийн ИТХ-ын даргын 2023.12.28-ний өдрийн а/62 тоот захирамжаар гаргасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1²-д заасан хэсгийг зөрчсөн байна.

Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 15 ор /Бат-Өлзий сум/ Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/62 дугаар захирамжид тус ЭМТ-ийн барилгыг 1,909.9 сая төгрөгөөр бүртгэхээр тогтоосныг зөрчиж, 2023 оны санхүүгийн тайланд 1,356.4 сая төгрөгөөр бүртгэсэн;

Сургуулийн барилга, 440 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/-тай сургуулийн барилгыг Бако констракшн ХХК гүйцэтгэсэн тус барилга угсралтад уурын зуухын барилга, тоног төхөөрөмж, гүнийн худаг нийт 692.0 сая төгрөгийн хөрөнгийг салгаж бүртгэлд тусгаагүй. Эдгээр хөрөнгийг гүйцэтгэгч Бако констракшн ХХК нь тус сумын иргэн Нямдаваад ашиглах эрхийг шилжүүлж өгсөн зөрчил илэрлээ.

Ашиглалтад оруулаагүй байгаа 2 барилгыг улсын комисс ажиллуулж хүлээн авч зөрчлийг арилгаж ажиллах, ашиглагч байгууллагад хөрөнгийг бүртгэн элэгдэл хоригдлыг тооцох, барилга ашиглалтад оруулах комисс хүлээн авах комиссын акт үндэслэн үндсэн хөрөнгөд бүртгэж байх.

Бүлэг 3. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна

В.1. Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023 онд 29 барилга байгууламжийг ашиглалтад оруулж үйл ажиллагааг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж хүлээлгэн өгсөн дараах төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаж байна. Тухайлбал:

- Үерийн далангийн ажил хийгдсэнээр Хархорин сумын Мойлт ба Арцатын багийн гэр хорооллын 1800 орчим өрх үерт автах эрсдэлээс бүрэн хамгаалагдсан байна.
- Цагдаагийн тасгийн 2 барилга ашиглалтад орсноор нийт 24 алба хаагчийн ажил тухтай орчныг бүрдүүлж чадсан байна.



В.2. Өвөрхангай аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагыг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь хэрэгцээ шаардлагаа бүрэн хангаж төлөвлөсөн үр дүндээ хүрсэн хэдий ч зарим төсөл арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүндээ хүрч чадахгүй байна. Тухайлбал:

² “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана”

- Баянгол сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын хувьд 3-аас дээш жил үргэлжлэн хэрэгжиж байгаа, барилга угсралтын туршлагагүй гүйцэтгэгч шалгаруулсан, гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй зэргээс төсөвт өртөг нэмэгдэж, барилгын насжилтад нөлөөлөх,
- Арвайхээр сумын 50 ортой хүүхдийн эмнэлгийн барилгыг ажлыг бүрэн дуусгаагүй, хүлээн аваагүй байхад 2021 оноос барилгыг ашиглаж эхэлсэн.
- Тарагт сумын Тамгын газрын барилга 2019 онд эхэлсэн ч одоог хүртэл барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөөгүй энэ нь гүйцэтгэгч Хангамж-өргөө ХХК-ний хариуцлагагүйгээс болсон.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тайлан баталгаажуулах тушаал:



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/13

Арвайхээр сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ӨВА-2024/18-14-ШТА-ГА/-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Аймгийн Засаг дарга /И.Доржсүрэн/-д зөвлөсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг аудитын менежер /Д.Гансүх/, гүйцэтгэл-нийцлийн багийн ахлах аудитор /С.Шийлэгмаа/ нарт үүрэг болгосугай.
4. Тайланг Үндэсний аудитын газрын ГНАГ, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлсүгэй.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /С.Шийлэгмаа/-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

015010028

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын
газрын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний
А/18 тоот тушаалын хавсралт

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

6217143681

А0059 9044094

№	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая.төг/
1	хавсралтад дурдсан 9 аж ахуйн нэгж барилга угсралтын 10,828.5 сая төгрөг /Арван тэрбум долоон зуун гучин есөн сая найман зуу/-ийн төсөвт тусгагдсан ажлыг чанаргүй гүйцэтгэсэн.	354/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	10,828.5
2	“Эрдэнэ зуу музейн аялал жуучлалын гудамж” төслийн 1,410.6 сая төгрөгийн дуусаагүй ажлыг аймгийн ЗДТГ-ын дуусаагүй барилга байгууламжаас хасаж, Хархорин сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгө бүртгэх аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн а/62 тоот захирамжаар бүртгэсэн байна. Тус байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт гараагүй байхад үндсэн хөрөнгөд бүртгэсэн.	355/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	1,410.6
3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд бий болсон 1,909.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ортой эмнэлгийн барилгыг санхүүгийн тайланд бүртгэхдээ 553.5 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	356/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	553.5
4	Сургуулийн барилга, 440 суудал /Өвөрхангай, Бат-Өлзий сум/-тай сургуулийн барилгыг Бако констракшн ХХК гүйцэтгэсэн тус барилга угсралтад уурын зуухын барилга, тоног төхөөрөмж, гүнийн худаг нийт 692.0 сая төгрөгийн хөрөнгийг салгаж бүртгэлд тусгаагүй. Эдгээр хөрөнгийг гүйцэтгэгч Бако констракшн ХХК нь тус сумын иргэн Н.Нямдаваад ашиглах эрхийг шилжүүлсэнд сумын удирдлагын зүгээс ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.	357/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	692.0
5	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 37 барилга байгууламжид техникийн хяналтыг үе шаттай хэрэгжүүлэхээр захиалагч ХБТХОХэлтэстэй, гүйцэтгэгчээр ГХБХБГ-ын дарга Т.Ариунболд, БХБХ-ийн дарга А.Энхцэцэг нар гэрээ байгуулж хяналтыг хэрэгжүүлж байна. Гэтэл техникийн хяналтыг хийж байгаа БХБХ-ийн инженерүүд нь хяналтаар өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлтийг дүгнэж үнэлэхгүйгээр орхигдуулсны улмаас барилга чанаргүй баригдах эрсдэл үүссэн, захиалагчтай байгуулсан гэрээний үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна..	358/A1560348/ӨВА-2024/18-14-ШТА-ГА	
	Нийт дүн		13,484.6

Холбогдох байгууллагын санал:



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР**

Рашаант 338, 8 дугаар баг,
Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62169,
Утас/факс: (976) 7032 3720,
Цахим шуудан: uvurkhangai@gazar.gov.mn,
Цахим хуудас: www.ovorkhangai.gazar.gov.mn

2024.04.19 № 155
танай 2024.04.17 -ны № 241 -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**


Танай байгууллагаас ирүүлсэн 241 тоот албан бичигтэй танилцлаа.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд санал хүргүүлж байна.

Хавсралт ⁴ хуудастай.

ДАРГА

Т.АРИУНБОЛД



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргүүлэх тухай

Танай газраас “Улс болон орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийсэн дүгнэлттэй танилцлаа.

1. Техник хяналтын ажлын талаар:

Улс төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх, төсвийг зарцуулах, хяналт тавих эрх шилжин ирж он дамжин хэрэгжсэн барилга угсралтын 30 ажил, инженерийн шугам сүлжээний 3 ажил, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн барилга угсралтын 4 ажил, засварын 30 ажил нийт 67 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийн ажилласан.

Эрх шилжиж ирээгүй буюу Уянга, Хужирт, Бат-Өлзий суманд хэрэгжиж буй “Сумын төвийн хөгжил” төсөл, “Төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих” төслийн 3 дугаар ээлжийн 6 ажил /Нарийнтээл сумын Баянтээг баг, Гучин-Ус, Төгрөг, Сант, Зүүнбаян-Улаан сум, Уянга сумын Жаргалант баг/, барилга байгууламжийн угсралтын 4 ажил, засварын 3 ажил нийт 16 төсөл арга хэмжээнд “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-тай хамтран захиалагчийн хяналт хийж ажилласан. 2023 онд нийт 83 төсөл арга хэмжээнд техникийн хяналт хийн ажиллаж эрх шилжиж ирсэн 22 барилга, байгууламж, 26 засварын ажил, эрх шилжээгүй 2 байгууламж, 3 засварын ажилд комисс зохион байгуулж ашиглалтад оруулсан.

2023 онд Барилга, байгууламжийн 22 ажлыг ашиглалтад оруулахын өмнө зураг төсөл зохиогч, техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан. Барилга угсралтын ажлын явцын мэдээг сар бүр гарган холбогдох яамд, ХОХБТХ-т хүргүүлдэг.

А. Хужирт сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн дээврийн парпеданд хийгдсэн шавардлага нь хар цаасны ам дарах зориулалтаар зургийн дагуу хийгдсэн. Хуучин барилгын зуухны барилгын дотор 2 барилгын дулааны узелийг нэгтгүүлж угсруулсан. Цахилгааны шитийг дотор оруулсан. Хаалга гаргах ажлыг ашиглагчийн хүсэлтээр гаргуулсан. Дээрх ажлууд ажлын тоо хэмжээнд байгаагүй. Ханын хагарал, цоклын шаврын засвар, шатны хонгилын ханын өнгөлгөөг засах ажлыг дулааны улиралд чанарын баталгаат хугацаанд гүйцэтгүүлнэ.

Б. Уянга сумын Сургуулийн барилгын урлаг заал, номын сан бүхий өргөтгөлийн барилгын арагт бүтээцийн цутгалтын ажлын нягтруулалтаас хамаарсан алдааг өндөр марктай зуурмагаар шавардуулж засах арга хэмжээг авна. Тус барилгын бетонд 2022 онд ШУТИС-ийн “Оношилгоо, зураг төсөл судалгааны Реконстракшн төв”-өөр хөндлөнгийн дүгнэлт гаргуулж арчилгааг хийж цааш нь үргэлжлүүлэх дүгнэлт гаргуулсан болно.

В. Уянга сумын Жаргалант багийн 120 хүүхдийн сургуулийн барилгын арагт бүтээцийн цутгалтын ажлын нягтруулалтаас хамаарсан алдааг гадна агаарын температур +10 градус болж тогтворжсоны дараа үл эвдэх аргаар бетоны бат бэхийг дахин үзэж үр дүнгээс хамаарсан холбогдох арга хэмжээг авна. Шалны дулаалгыг зохиогчоос өгсөн зөвлөмжийн дагуу 20 см зузаантай хүрмэн чулуун дулаалгыг хийж цутгалт хийсэн. Зөвлөмжийг талбайн журналд тэмдэглэж зохиогч баталгаажуулсан.

Г. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 15 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум, 5 дугаар баг/ Комиссын гишүүдийн үүрэг даалгавар биелэгдсэн. Тааз нь нян бактери устгагчтай, эмнэлгийн зориулалттай металл дүүжин таазыг зориулалтын дагуу угсарсан. Агааржуулалтын төхөөрөмжийн ажиллахгүй болсон шалтгааныг тодруулж баталгаат хугацаанд нь гүйцэтгэгчээр засуулна.

Д. Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, /Өвөрхангай, Хужирт сум/ Санхүүгийн чадамжгүй компани шалгарснаас ажлын гүйцэтгэгч байнга солигдож ажил удааширсан, барилгын чанарт нөлөөлсөн

Е. Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 100 ор /Өвөрхангай, Хархорин сум/

Тус барилгын ханын өрлөгийн зузаан зөрүүтэй хийгдсэн талаар зураг төслийн компанид мэдэгдэж дүгнэлт гаргуулах хүсэлтийг өгсөн. Барилгын дулаан алдагдлыг нэмэгдүүлэхгүйн тулд барилгын гадна ханын дотор талд дулаалга нэмж хавтангаар өнгөлөх шийдэлд хүрч авторын дүгнэлт гаргуулсан. Хамар ханын өрлөгийг засуулж биелэлтийг хүргүүлнэ.

Ё. Зооноз өвчин судлалын төвийн барилга, 15 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум, 5-р баг/ Тус барилгад 2 удаа үерийн ус орж нэлээд гэмтэл үүсгэсэн. 1 дүгээр сард үзлэг хийж дотор заслын ажлыг гүйцэтгүүлсэн. Гадна талд үүссэн эвдрэл гэмтлийг дулааны улиралд гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч компанитай тохирсон болно.

Ж. Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Хайрхандулаан сум, 6 дугаар баг/ Тус барилгад үүссэн зөрчлийг чанарын баталгаат хугацаанд арилгуулж биелэлтийг хүргүүлэх болно.

Хүйтний улиралд ашиглалтад орсон барилга байгууламжийн гадна тохижилт гэх мэт дулааны улиралд хийгдэх ажлыг 6-7 дугаар сарын 1-ний дотор гүйцэтгүүлэхээр тохирч ашиглалтанд оруулсан барилгууд байна. Дутуу ажлыг тохирсон хугацаанд гүйцэтгүүлэх болно.

Хөдөө орон нутагт хийгдэж байгаа ажилд зарим тохиолдолд очиж амжихгүй байх тохиолдол байна. 2024 оноос хяналтын инженерийн орон тоог 2 гэрээт инженерээр нэмэгдүүлж унааны хангамжийг нэмэгдүүлж байна.Цаашид техник хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд анхаарч ажиллах болно.

Зөрчлийн мөнгөн дүнг ажил тус бүрийн зөрчилтэй ажилд ногдох үнийн дүнгээр тооцох нь зүйтэй гэж үзэж байна.

2. Зураг төслийн талаар:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөгдөж байгаа салбарын сайдуудын багцын барилга байгууламжуудад БХБС-ын 2018 онд шинэчлэн баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм” үлгэрчилсэн загварын дагуу архитектур төлөвлөлт, зургийн даалгаврыг боловсруулж холбогдох газрын даргаар хянуулж аймгийн Засаг даргаар баталгаажуулан ажиллаж байна.

Тайлбар: А.1.1.

Хархорин сумын 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын зургийн хүчил төрөгчийн хоолойн системийн зургийн ажлын төсөв 2023 онд ЭМС-ын төсвөөс шийдэгдэж үндсэн ажлын зургийн гүйцэтгэгч “Бэс онцгой” ХХК ЭМЯ-тай гэрээ байгуулан нэмэлтээр хийж гүйцэтгэн БХТ-ийн Магадлалаар батлагдах шатандаа байна.

Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн ажлын зурагт сумын эмнэлэгийн зүгээс шаардлагатай өрөө тасалгааны саналыг авч зурагт тусгуулан ажилласан. Тус саналд төрөх тасгийн санал байгаагүй болно. Иймд ЭМТөвийн ажлын зургийн гүйцэтгэгч “Жаргалант хийц” ХХК-д шаардлага тавьж тус барилгын 2 давхарт төрхийн өрөө тасалгааг төлөвлүүлэн хүлээж авсан.

А.1.2. А.1.3.

Баянгол сумын 240 хүний суудалтай соёлын төвийн тухайн үеийн улсын төсөвтэй холбоотойгоор сумын Засаг дарга сумын өөрийн бололцоогоор буулгахаар шийдсэн учир хуучин барилгыг буулгах ажлын зургийг хийлгээгүй болно.

Аймгийн шинэ музейн барилгын ажлын зургийг “Балданс” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд тухайн барилгын төсөв бага 5 тэрбум төгрөг батлагдсан тул үзүүлэг дэглэлтийн интерьерийн зургийг тусад нь хийлгэхээр аймгийн ХОХБТХ-тэй ярилцаж ажлын зурагт дотор талын зургийг энгийн засалтай байхаар хийлгэж хүлээн авсан болно. Барилгын үзүүлэг дэглэлтийн интерьерийн зургийн төсөв тусдаа батлагдсан болно.

Хужирт сумын 400 хүний суудалтай соёлын төвийн барилга хуучин соёлын төвийн барилгыг буулгаж барихаар төлөвлөгдөж байсан боловч сумын Засаг дарга удирдлагуудын хүсэлтээр одоогийн байршилд байршуулсан. Тухайн шинэ байршилд байсан инженерийн шугам сүлжээг зөөх нэмэлтээр шугамын ажлын

зураг төсөв хийлгэх магадлашгүй нөхцөл байдал үүсэж ажлын зургийн гүйцэтгэгч “Зэд прожект” ХХК-аар трассын зураг хийлгэж хүлээн авсан.

Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн ажлын зургийн даалгаварт гадна гэрэлтүүлэг тохижилтын зургийг бүрэн хийлгэхээр тусгасанч “Жаргалант хийц” ХХК барилгын төсөвтэй холбоотойгоор гадна цахилгааны зураг тоо хэмжээг хасаж оруулан магадлалаар батлуулсан.

Хархорин сумын 100 ортой нэгдсэн эмнэлэгийн барилгын ажлын зургийн хүчил төрөгчийн хоолойн системийн зургийн ажлын төсөв сүүлд шийдэгдэж ЭМСайдын багцын төсвийн нэмэлтээр хийгдэж БХТ-ийн Магадлалаар батлагдах шатандаа байна.

Богд сумын Эрүүл мэндийн төвийн ажлын зураг төсөвт тохижилтын ажлын зураг тоо хэмжээ төлөвлөгдөж зургийн дагуу тохижилтын ажил хийгдсэн болно.

A.1.4.

Хужирт сумын 400 хүний суудалтай соёлын төвийн барилгын байршлын өөрчлөлтөөс шалтгаалан ажлын зургаас магадлалын төсөв зөрсөн асуудал үүссэн болно.

Хархорин сумын 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын зураг, магадлалын төсөв, тоо хэмжээнд дутуу тооцсон зүйлгүй үе шатны экпэртээр орж баталгаажсан ажлын зургийг хүлээн авсан.

Хужирт сумын Эрүүл мэндийн төвийн ажлын зургийн гадна өндөржилтийн зурагт үе шатны экспертизээр орж баталгаажсан болно.

Улс төсвийн хөрөнгө оруулалтын барилгын төсөв, магадлалын төсөв, байршил магадлашгүй ажил стандарт норм дүрмийн харилцан адилгүй уялдаа холбооноос болон барилгын ажлын зураг магадлалын төсөвт зөрүү зөрчил үүсэх магадлал өндөр байгаа нь үнэн болно.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

Үүнд:

БҮЛЭГ 1. Эрүүл мэндийн сайдын багцаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга байгууламжийн зураг, төслийг боловсруулах зургийн даалгаварт мөрдөгдөх Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 03 дугаар тушаалаар батлагдсан "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" /БНБД 31-22-21³/ дүрмийг тусгайлан авч боловсруулаагүй байна.

БҮЛЭГ 2. Захиалагчтай гэрээ байгуулсан техник хяналт, зохиогчийн үе шатны хяналт хангалтгүйгээс зарим барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хийгээгүй, ажлын гүйцэтгэл чанаргүй байна.

БҮЛЭГ 3. Зарим нэг төсөл арга хэмжээнүүд нь чанаргүй гүйцэтгэсэн ч хэрэгцээг хангаж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга И.Доржсүрэнд:

1. Хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах;
2. Захиалагч нь зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний үүргийг бүрэн хангуулах, хэрэгжүүлсэн хяналтын үр дүнд тохирсон санхүүжилтийг олгох;
3. Техникийн хяналт гүйцэтгүүлэх гэрээнд заасан захиалагч, гүйцэтгэгчийн эрх, үүргийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж санхүүжилтийг олгох;

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Т.Ариунболдод:

1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссоос өгсөн үүрэг даалгаврыг комиссын гишүүн тус бүрээр нь гаргуулж биелэлтийг тооцсоны үндсэн дээр ашиглалтад хүлээн авах.